



## САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Сэлэнгэ аймгийн Хушаат сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: СЭА-2024/194/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.selenge@audit.gov.mn](http://www.selenge@audit.gov.mn)

Сүхбаатар сум  
2024 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа

Утас: 70363040 Цахим хаяг: [enkhtuyach@audit.gov.mn](mailto:enkhtuyach@audit.gov.mn)

Аудитын менежер: Б.Батмөнх

Утас: 70363036 Цахим хаяг: [batmunkhb@audit.gov.mn](mailto:batmunkhb@audit.gov.mn)

Аудитор: Б.Ундаръяа

Утас: 70376994 Цахим хаяг: [undariya@gmail.com](mailto:undariya@gmail.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

1. АУДИТЫН ДҮГНЭЛТ .....	<b>Error! Bookmark not defined.</b>
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	9
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА .....	10
3.1. Байгууллага, түүний үйл ажиллагаа.....	10
3.2. Байгууллагын гадаад, дотоод орчин .....	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	11
3.4. Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд..	11
3.5. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	12
3.5.1 Төсвийн төлөвлөлт .....	13
3.5.2 Төсвийн гүйцэтгэл.....	13
3.5.3 Нэмэлт төсөв:.....	14
3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл.....	14
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	14
4.1 Ерөнхий зүйл.....	14
4.2. Материаллаг байдал.....	15
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	15
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	15
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	16
4.5.1 Завсрын аудитын талаар.....	16
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн .....	16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	16
Дараах асуудлыг дээд шатны төсвийн захирагчийн санхүүгийн тайланд хийх аудитын анхааралд хандуулж байна. Үүнд:.....	16
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	16
5.1 Төлбөрийн акт .....	17
5.2 Албан шаардлага .....	17
6. АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ .....	18

### Товчилсон үгийн жагсаалт

ААНБ	Аж ахуй нэгж байгууллага
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БШУГ	Боловсрол, шинжлэх ухааны газар
БШУС	Боловсрол, шинжлэх ухааны сайд
БШУЯ	Боловсрол, шинжлэх ухааны яам
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ТБОНӨХБАҮХА	Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ, худалдан авах
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,  
Сэлэнгэ аймаг, 43081  
Утас/Факс: (976)-7036-3040  
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

ХУШААТ СУМЫН  
1 ДҮГЭЭР ЦЭЦЭРЛЭГИЙН  
ЭРХЛЭГЧ О.БЯМБАЦЭЦЭГ ТАНАА

2024. 02. 23 № СЭА-2024/194/НА-СТА-ТШЗ  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Хушаат сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн хэсэгт дурдсан зөрчлийг материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд түүний санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд үзүүлэх нөлөөг эс тооцвол Хушаат сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлүүд нь бидний тогтоосон 3,280.9 мянган төгрөгийн материаллаг байдлын түвшнээс өндөр бөгөөд Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.4.8, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтын 4.2 дахь заалтуудтай тус тус нийцээгүй байна.

### Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд сумын ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар 12,000.0 мянган төгрөгийн тоглоом, тоног төхөөрөмж, тавилга эд хогшлыг үнэ төлбөргүй хүлээн авсан байна.

### **Аудитын гол асуудал**

Нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд мөрдөж байгаа БШУС-ын 2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/22 дугаар тушаалаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг” нь гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжиж байгаа байгууллагын онцлогт тохироогүй, үр дүнд суурилсан төсөвлөлт, санхүүжилт, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний бүртгэлийн талаар нарийн тусгаагүй байна.

Байгууллагын төсөв, санхүүжилтийг зардлын эдийн засгийн ангиллаар нь бус “бараа үйлчилгээний бусад зардал” гэсэн ангиллаар бөөнд нь тусган, төлөвлөж, баталж байгаа нь төсвийг зардлын бүлэг, зүйлээр төлөвлөж, зарцуулах, зарцуулалтад хяналт тавих зарчмыг алдагдуулж байна.

### **Бусад асуудлын хэсэг**

Тус байгууллага нь тайлант оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд **3** зорилтын хүрээнд **24** арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, **89.0** хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

<i>/төгрөгөөр/</i>			
Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>24,877,470.07</b>	<b>98,041,759.66</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>8,895,265.64</b>	<b>67,977,387.81</b>
<b>31100</b>	<b>Кассанд байгаа бэлэн мөнгө</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
<b>31200</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	<b>8,895,265.64</b>	<b>67,977,387.81</b>
<b>31210</b>	<b>Төгрөг</b>	<b>8,895,265.64</b>	<b>67,977,387.81</b>
31211	Төрийн сангийн харилцах	8,895,265.64	67,977,387.81
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>0.00</b>	<b>146,166.00</b>
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	0.00	146,166.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>15,982,204.43</b>	<b>29,918,205.85</b>
<b>35100</b>	<b>Түүхий эд материал</b>	<b>0.00</b>	<b>2,110,300.00</b>
35110	Тусгай зориулалттай материал	0.00	2,110,300.00
<b>35400</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>15,982,204.43</b>	<b>27,807,905.85</b>
35410	Бичиг хэргийн материал	719,360.00	616,060.00
35420	Аж ахуйн материал	11,374,588.00	12,153,543.00
35460	Хүнсний материал	3,888,256.43	10,617,602.85
35470	Бусад хангамжийн материал	0.00	4,420,700.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>489,384,773.74</b>	<b>490,961,443.43</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>489,384,773.74</b>	<b>490,961,443.43</b>
39100	Газар	0.00	0.00
<b>39200</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>480,620,586.24</b>	<b>482,197,255.93</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	175,026,127.00	175,026,127.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(20,347,120.27)	(24,932,025.91)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	25,664,835.00	34,474,835.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(7,258,533.81)	(10,183,858.89)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	12,969,593.90	13,739,293.90
39208	Хуримтлагдсан элэгдэл	(5,434,315.58)	(5,927,115.17)
39216	Дуусаагүй барилга, байгууламж	300,000,000.00	300,000,000.00
<b>39300</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>8,764,187.50</b>	<b>8,764,187.50</b>
39301	Програм хангамж	225,000.00	225,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(182,812.50)	(182,812.50)
39303	Бусад биет бус хөрөнгө	8,722,000.00	8,722,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>514,262,243.81</b>	<b>589,003,203.09</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>0.00</b>	<b>1,550,891.26</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>0.00</b>	<b>1,550,891.26</b>
<b>41300</b>	<b>Өглөг</b>	<b>0.00</b>	<b>1,550,891.26</b>
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	0.00	1,550,891.26
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>514,262,243.81</b>	<b>587,452,311.83</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>514,262,243.81</b>	<b>587,452,311.83</b>
51100	Засгийн газрын оруулсан капитал	375,685,548.00	375,685,548.00
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	375,685,548.00	375,685,548.00
<b>51200</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>38,123,485.48</b>	<b>111,313,553.50</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	(476,136,659.83)	38,123,485.48
51220	Тайлант үеийн үр дүн	514,260,145.31	73,190,068.02
51230	Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс	0.00	0.00
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	100,453,210.33	100,453,210.33
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>514,262,243.81</b>	<b>589,003,203.09</b>

## 2.2 Аудит хийсэн САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>850,939,051.62</b>	<b>500,985,445.99</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>510,840,727.62</b>	<b>12,435,455.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>510,840,727.62</b>	<b>12,435,455.00</b>
<b>120004</b>	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>0.00</b>	<b>70,000.00</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	70,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	495,019,665.67	9,579,700.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	15,821,061.95	2,785,755.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>340,098,324.00</b>	<b>488,549,990.99</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>287,291,500.00</b>	<b>441,617,500.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	287,291,500.00	441,617,500.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>52,806,824.00</b>	<b>46,932,490.99</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	52,806,824.00	46,932,490.99
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>336,678,906.31</b>	<b>427,795,377.97</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>336,678,906.31</b>	<b>427,795,377.97</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>329,112,406.31</b>	<b>427,795,377.97</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>218,363,083.36</b>	<b>290,007,507.09</b>
210101	Үндсэн цалин	160,097,546.61	204,776,792.27
210102	Нэмэгдэл	41,425,433.90	76,089,030.92
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0.00	0.00
210104	Урамшуулал	5,295,753.85	9,141,683.90
210105	Гэрээт ажлын хөлс	11,544,349.00	0.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>26,173,298.50</b>	<b>42,453,304.74</b>
210201	Тэтгэврийн даатгал	17,580,498.50	29,118,610.91
210202	Тэтгэмжийн даатгал	2,158,600.00	3,425,523.09
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,738,000.00	2,740,652.68
210204	Ажилгүйдлийн даатгал	419,800.00	635,638.75
210205	Эрүүл мэндийн даатгал	4,276,400.00	6,532,879.31
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>37,048,175.00</b>	<b>40,483,382.25</b>
210301	Гэрэл, цахилгаан	4,737,275.00	5,725,990.99
210302	Түлш, халаалт	32,007,000.00	33,557,391.26
210303	Цэвэр, бохир ус	303,900.00	1,200,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>25,332,157.52</b>	<b>29,347,253.58</b>
210502	Хоол, хүнс	25,332,157.52	29,347,253.58
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>3,000,000.00</b>	<b>8,000,000.00</b>
210604	Урсгал засвар	3,000,000.00	8,000,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>592,000.00</b>	<b>699,200.00</b>
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	592,000.00	699,200.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>18,603,691.93</b>	<b>16,804,730.31</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,718,800.00	7,384,200.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,250,000.00	1,417,500.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	5,634,891.93	8,003,030.31
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>7,566,500.00</b>	<b>0.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>7,566,500.00</b>	<b>0.00</b>

213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	7,566,500.00	0.00
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>514,260,145.31</b>	<b>73,190,068.02</b>
<b>IV</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
<b>V</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>514,260,145.31</b>	<b>73,190,068.02</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>340,098,324.00</b>	<b>488,619,990.99</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>0.00</b>	<b>70,000.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>0.00</b>	<b>70,000.00</b>
<b>120004</b>	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>0.00</b>	<b>70,000.00</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	70,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>340,098,324.00</b>	<b>488,549,990.99</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>287,291,500.00</b>	<b>441,617,500.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	287,291,500.00	441,617,500.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>52,806,824.00</b>	<b>46,932,490.99</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	52,806,824.00	46,932,490.99
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>331,203,058.36</b>	<b>429,537,868.82</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>331,203,058.36</b>	<b>429,537,868.82</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>323,636,558.36</b>	<b>429,537,868.82</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>218,363,083.36</b>	<b>290,153,673.09</b>
210101	Үндсэн цалин	160,097,546.61	204,922,958.27
210102	Нэмэгдэл	41,425,433.90	76,089,030.92
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0.00	0.00
210104	Урамшуулал	5,295,753.85	9,141,683.90
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>26,171,200.00</b>	<b>42,453,304.74</b>
210201	Тэтгэврийн даатгал	17,578,400.00	29,118,610.91
210202	Тэтгэмжийн даатгал	2,128,600.00	3,425,523.09
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,738,000.00	2,740,652.68
210204	Ажилгүйдлийн даатгал	429,800.00	635,638.75
210205	Эрүүл мэндийн даатгал	4,296,400.00	6,532,879.31
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>37,048,075.00</b>	<b>38,932,490.99</b>
210301	Гэрэл, цахилгаан	4,737,275.00	5,725,990.99
210302	Түлш, халаалт	32,007,000.00	32,006,500.00
210303	Цэвэр, бохир ус	303,800.00	1,200,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>25,493,300.00</b>	<b>36,076,600.00</b>
210502	Хоол, хүнс	25,493,300.00	36,076,600.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>3,000,000.00</b>	<b>8,000,000.00</b>
210604	Урсгал засвар	3,000,000.00	8,000,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>592,000.00</b>	<b>699,200.00</b>
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	592,000.00	699,200.00

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	12,968,900.00	13,222,600.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,718,900.00	11,124,900.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,250,000.00	2,097,700.00
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>7,566,500.00</b>	<b>0.00</b>
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>7,566,500.00</b>	<b>0.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	7,566,500.00	0.00
III	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>8,895,265.64</b>	<b>59,082,122.17</b>
IV	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
V	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
VI	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
VII	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
VIII	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	<b>8,895,265.64</b>	<b>59,082,122.17</b>
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	8,895,265.64
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	8,895,265.64	67,977,387.81

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	375,685,548.00	100,453,210.33	(476,136,659.83)	2,098.50
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	375,685,548.00	100,453,210.33	(476,136,659.83)	2,098.50
7	Өмчид гарсан өөрчилөлт	0.00	0.00	0.00	0.00
9	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	514,260,145.31	514,260,145.31
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	375,685,548.00	100,453,210.33	38,123,485.48	514,262,243.81
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	375,685,548.00	100,453,210.33	38,123,485.48	514,262,243.81
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	375,685,548.00	100,453,210.33	38,123,485.48	514,262,243.81
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	73,190,068.02	73,190,068.02
20	2023 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	375,685,548.00	100,453,210.33	111,313,553.50	587,452,311.83

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>497,445,190.09</b>	<b>429,537,867.92</b>	<b>67,907,322.17</b>	86.3
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>450,512,700.00</b>	<b>382,605,377.83</b>	<b>67,907,322.17</b>	84.9
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>450,512,700.00</b>	<b>382,605,377.83</b>	<b>67,907,322.17</b>	84.9
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>346,236,800.00</b>	<b>290,153,673.09</b>	<b>56,083,126.91</b>	83.8
210101	Үндсэн цалин	230,545,300.00	204,922,958.27	<b>25,622,341.73</b>	88.9
210102	Нэмэгдэл	104,125,700.00	76,089,030.92	<b>28,036,669.08</b>	73.1
210104	Урамшуулал	11,565,800.00	9,141,683.90	<b>2,424,116.10</b>	79.0
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>50,382,700.00</b>	<b>42,453,304.74</b>	<b>7,929,395.26</b>	84.3
210201	Тэтгэврийн даатгал	34,260,600.00	29,118,610.91	<b>5,141,989.09</b>	85.0
210202	Тэтгэмжийн даатгал	4,030,400.00	3,425,523.09	<b>604,876.91</b>	85.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,224,600.00	2,740,652.68	<b>483,947.32</b>	85.0
210204	Ажилгүйдлийн даатгал	805,500.00	635,638.75	<b>169,861.25</b>	78.9
	<b>Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал</b>	<b>38,932,490.09</b>	<b>38,932,490.09</b>	<b>0.00</b>	100.0
210301	Гэрэл, цахилгаан	5,725,990.09	5,725,990.09	<b>0.00</b>	100.0
210302	Түлш, халаалт	32,006,500.00	32,006,500.00	<b>0.00</b>	100.0
210303	Цэвэр, бохир ус	1,200,000.00	1,200,000.00	<b>0.00</b>	100.0
	Эд хогшил, урсгал засварын зардал	<b>8,000,000.00</b>	<b>8,000,000.00</b>	<b>0.00</b>	100.0
210604	Урсгал зардал	8,000,000.00	8,000,000.00	<b>0.00</b>	100.0
210304	Норматив зардал	<b>39,971,400.00</b>	<b>36,076,600.00</b>	<b>3,894,800.00</b>	90.3
210502	Хоол, хүнс	39,971,400.00	36,076,600.00	<b>3,894,800.00</b>	90.3
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>699,200.00</b>	<b>699,200.00</b>	<b>0.00</b>	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	699,200.00	699,200.00	<b>0.00</b>	100.0
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>13,222,600.00</b>	<b>13,222,600.00</b>	<b>0.00</b>	100.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	11,124,900.00	11,124,900.00	<b>0.00</b>	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,097,700.00	2,097,700.00	<b>0.00</b>	100.0
III	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>450,512,700.00</b>	<b>441,687,500.00</b>	<b>8,825,200.00</b>	98.0
31	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>441,617,500.00</b>	<b>441,617,500.00</b>	<b>0.00</b>	100.0
310001	Улсын төсвөөс санхүүжих	441,617,500.00	441,617,500.00	<b>0.00</b>	100.0
	Орон нутгийн төсвөөс	46,932,490.09	46,932,490.09		
35	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>8,895,200.00</b>	<b>70,000.00</b>	<b>8,825,200.00</b>	0.8
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0	70,000.00	70,000.00	0.0
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	8,895,200.00	0	0.00	0.0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	8,895,265.64	0.00	0.0
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	67,977,387.81	0.00	0.0

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Хушаат сумын 1 дүгээр цэцэрлэг нь “Хүүхдийн болон багшийн бүх талын тасралтгүй хөгжлийг хангахад хамтран ажиллах” гэсэн зорилт тавин ажиллаж байна.

Үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Суралцагчдыг цэцэрлэгтээ айдасгүй, амар тайван суралцаж, суралцахуйн хоцрогдолгүйгээр эрүүл аюулгүй, тэгш хүртээмжтэй орчинд сурч хөгжих боломжийг бүрдүүлж “Чадварлаг багш”, “Сургалтын байгууллага-тоног төхөөрөмж” арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх
- Сургалтын байгууллагын болон багшийн ажлын гүйцэтгэлд суурилан тасралтгүй хөгжих олон хэлбэрт сургалт, үйл ажиллагааг зохион байгуулж, менежментийг сайжруулах
- Багш, ажилтан бүр ёс зүйн хэм хэмжээ, шаардлагыг мөрдөж, төсвийг төлөвлөх, үр ашигтай зарцуулахад идэвхтэй оролцох
- Багш бүр ээлжит хичээлийн цахим контентын санг бүрдүүлэхэд оролцох, бүтээлчээр ашиглах
- Мэргэжлийн хөгжлийн бүлгийн үйл ажиллагааг өргөжүүлж, зөвлөх, тэргүүлэх багшийн манлайлал, үүрэг оролцоог нэмэгдүүлэх

#### 3.2. Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Боловсролын ерөнхий хууль 2023 оны 07 дугаар сарын 07-нд батлагдсан,
- Хөдөлмөрийн тухай хуульд 2023 оны 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Төрийн хэмнэлтийн тухай хуульд 2023 оны 06 дугаар сарын 16, 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 241 дүгээр тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон,
- БШУС-ын 2023 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн 1/2714 тоот албан бичгээр боловсролын байгууллагын төсвийн шинэчлэлийн хүрээнд “1.ЕБС-д сургалтын тоног төхөөрөмжийн нөхөн хангалт шийдвэрлэх”, “2.Цэцэрлэгт шаардлагатай хүүхдийн тоглоом,наадгай, зөөлөн эдлэл ханган нийлүүлэх,худалдан авах ажиллагааг зохион байгуулах” чиглэлийг хүргүүлсэн гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын

сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналт, үйл ажиллагааны зохион байгуулалтын хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Тайлант онд тус цэцэрлэгийн санхүүгийн үйл ажиллагаанд БШУЯ-ны Хяналт-шинжилгээ, үнэлгээний газрын Дотоод аудитын хэлтсээс хяналт, шалгалт хийгдээгүй боловч сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, шилэн дансны мэдээллээр дамжуулан дотоод хяналт, шалгалтыг хэрэгжүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хушаат сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

Тус цэцэрлэг нь Боловсрол, Шинжлэх Ухааны сайдын 2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/22 дугаар тушаалаар баталсан Боловсрол, Шинжлэх Ухааны салбарын төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа төсөвт байгууллагуудад мөрдөгдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн хэдий ч гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжиж байгаа байгууллагын онцлогт тохироогүй, үр дүнд суурилсан төсөвлөлт, санхүүжилт, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний бүртгэлийн талаар нарийн тусгаагүй байна.

### **3.4. Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд**

Хушаат сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 74,671.0 мянган төгрөгөөр буюу 12.6 хувиар өссөн байна.

## Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	8,895.20	67,977.40	59,082.20
Авлага	-	146.2	146.20
Бараа материал	15,982.20	29,918.20	13,936.00
Үндсэн хөрөнгө	489,384.80	490,961.40	1,576.60
<b>Нийт хөрөнгө</b>	<b>514,262.20</b>	<b>589,003.20</b>	<b>74,741.00</b>
Өр төлбөр	-	1,550.9	1,550.9
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	514,262.20	587,452.3	73,190.1
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>514,262.20</b>	<b>589,003.20</b>	<b>74,741.00</b>

Дээрх хүснэгтээс үзэхэд дараах дансанд нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 67,977.4 мянган төгрөг болж 59,082.2 мянган төгрөгөөр өссөн нь Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.9<sup>1</sup>-д заасны дагуу гүйцэтгэлд суурилсан санхүүжилтэд шилжсэнээр төсвийн хэмнэлтийг төвлөрүүлээгүйгээс,
- Авлага дансны үлдэгдэл 146.2 мянган төгрөгөөр өссөн нь НДШ-ийн 79.8 мянган төгрөгийн илүү төлөлт, 66.4 мянган төгрөгийн цалин илүү олгосноос,
- Бараа материал дансны үлдэгдэл 29,918.2 мянган төгрөг болж 13,936.0 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 54,965.5 мянган төгрөгийн бараа материал худалдан авсан, сумын ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар 2,420.3 мянган төгрөгийн тоглоом, тооллогын бүртгэлээр илэрсэн 365.4 мянган төгрөгийн халуун хэмжигч, кварцын гэрлийг үнэ төлбөргүй хүлээн авч 43,815.2 мянган төгрөгийн бараа материал зарцуулснаас,
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 490,961.4 мянган төгрөг болж 1,576.7 мянган төгрөгөөр өссөн нь сумын ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар 8,810.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 769.7 мянган төгрөгийн тавилга эд хогшил үнэ төлбөргүй хүлээн авсан, 8,003.0 мянган төгрөгийн элэгдэл нэмж байгуулснаас,
- Өр төлбөр дансны үлдэгдэл 1,550.9 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь халаалтын зардлын өглөг үүссэнээс тус тус шалтгаалсан байна

### 3.5. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч

<sup>1</sup> Энэ хуулийн 7.7 дахь хэсэг эрүүл мэнд, боловсролын салбарын гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн зарчмаар санхүүждэг байгууллагын төсвийн захирагчид хамаарахгүй

нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус цэцэрлэгийн 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 431,671.0 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 48,932.0 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 480,603.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн төсвийн төслийн саналаас цалин хөлс, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардлыг 18,841.8 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, тогтмол зардлыг 1,999.5 мянган төгрөгөөр бууруулж нийт төсвийг **497,445.2** мянган төгрөгөөр баталсан байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 9 арга хэмжээг санхүүжүүлэхээр **497,445.2** мянган төгрөгийн төсөв баталснаас улсын төсвөөс 450,512.7 мянган төгрөгийг, орон нутгийн төсвөөс 46,932.5 мянган төгрөгийн эх үүсвэрийг урсгал үйл ажиллагаанд зарцуулахаар төлөвлөсөн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 429,537.8 мянган төгрөг буюу **86.3** хувьтай тайлагнагдсан нь цалин хөлс, НДШ-ийн зардлыг 61,522.9 мянган төгрөгөөр, хоолны зардлыг 3,894.8 мянган төгрөгөөр, нүүдлийн бүлэгт хамруулах зардлыг 2,489.7 мянган төгрөгөөр хэмнэгдсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

		<i>/мянган төгрөгөөр/</i>					
Д/д	Хөтөлбөр	Д/д	Арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	71802 Сургуулийн өмнөх боловсрол	1	81605-Эрүүл мэндийг дэмжих	1,048.90	1,048.90	-	100.0
		2	81807-Цэцэрлэгийн хүүхдийн хоол	39,243.70	35,348.90	(3,894.80)	90.1
		3	81816-Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	2,478.70	2,478.70	-	100.0
		4	81823-Боловсролын байгууллагын багш	1,368.90	1,368.90	-	100.0
		5	81832- Нүүдлийн бүлэгт хамруулах	5,011.70	2,522.00	(2,489.70)	50.3
		6	81834-Боловсролын стандарт сургалт	308,846.20	259,798.70	(49,047.50)	84.1
		7	81835-Сургалтын хэвийн үйл ажиллагаа	92,514.60	80,039.20	(12,475.40)	86.5
		8	80111-Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	38,932.50	38,932.50	-	100.0
		9	80112-Нийтлэг үйлчилгээ	8,000.00	8,000.00	-	100.0
<b>Нийт</b>				<b>497,445.20</b>	<b>429,537.80</b>	<b>(67,907.40)</b>	<b>86.3</b>

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв:

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Сангийн яамны 2022 оны 02 дугаар сарын 28-ны “Чиглэл хүргүүлэх тухай” албан бичгээр байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансыг хааж, нэмэлт санхүүжилттэй холбоотой гүйлгээг урсгал дансаар дамжуулан гүйцэтгэж, тайланг төсвийн гүйцэтгэлийн тайланд нэгтгэсэн байна.

### 3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд дараах худалдан авах ажиллагааны урилгыг ТБОНӨХБАУХА тухай хуульд заасны дагуу tender.gov.mn-д цахим сайтад байршуулж, зохион байгуулсан байна. Үүнд:

*/мянган төгрөгөөр /*

№	Тухайн жилд худалдан авах бараа, ажил, үйлчилгээний нэр төрөл, тоо, хэмжээ, хүчин чадал	Батлагдсан төсөв	Гэрээний дүн	Тендер шалгаруулалтын арга
1	Хүүхдийн хоол	39,243.7	36,076.6	НТШ
	<b>Нийт дүн</b>	<b>39,243.7</b>	<b>36,076.6</b>	

Бэлтгэн нийлүүлэгчийг сонгон шалгаруулах нээлттэй тендер шалгаруулалтад “Сэлэнгэ Шижир тулга” ХХК гүйцэтгэгчээр шалгаран 2023 оны 05 дугаар сарын 01-ний өдөр гэрээ байгуулан, худалдан авалтыг гүйцэтгэсэн байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Хушаат сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг тогтоосонд хугацаанд нь мэдээлж байх зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу аудитор Б.Ундаръяа гүйцэтгэж, хяналтыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Хушаат сумын 1 дүгээр цэцэрлэг нь 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг 2024 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 03 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### **4.2. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг 328,091.8 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 3,280.9 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

#### **4.3 ТӨРИЙН ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ**

Нэг сарын хэрэглээнээс илүү буюу 6,437.3 мянган төгрөгийн хүнсний материал худалдан авч нөөцөлсөн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6 дахь “нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

#### **4.4 САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТААР ШАЛГАСАН НИЙЦЛИЙН АУДИТЫН АСУУДАЛ**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант онд тус цэцэрлэг нь мэдээлбэл зохих 20 төрлийн 171 мэдээллээс цалингийн зардлаас бусад таван сая төгрөгнөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээний мэдээллийг 2 удаа хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Шийдвэрлэсэн нь: Дээрх зөрчил нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.4.3, 6.4.5, 6.4.7 дахь заалтуудыг зөрчсөн байгаа тул холбогдох мэдээллийг шилэн дансны цахим хуудаст тогтоосон хугацаанд мэдээлж байх зөвлөмж хүргүүлээ.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тайлант онд бусад хууль, тогтоомжийн хэрэгжилтэд хамаарах алдаа, зөрчил илрээгүй.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын 2023 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 123 дугаар албан бичгээр “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” захидлыг хүргүүлсэн бөгөөд тус сургуулийн 2022 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй болно.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар цалингаас суутгасан 756.6 мянган төгрөгийн ХХОАТ-ыг тайлагнаагүй зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгснийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

*Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт*

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	1	756.6	1	756.6	100
Нийт дүн	1	756.6	1	756.6	100

#### 4.6 ДАРААГИЙН АУДИТААР АНХААРАХ АСУУДАЛ

Дараах асуудлыг дээд шатны төсвийн захирагчийн санхүүгийн тайланд хийх аудитын анхааралд хандуулж байна. Үүнд:

1. Дээд шатны төсөв захирагчаас төсвийг зардлын эдийн засгийн ангиллаар нь бус “бараа үйлчилгээний бусад зардал” гэсэн ангиллаар бөөнд нь тусган, төлөвлөж, баталж байгаа нь төсвийг зардлын бүлэг, зүйлээр төлөвлөж, зарцуулах, зарцуулалтад хяналт тавих зарчмыг алдагдуулж байна.

#### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой нийт **16,838.2** мянган төгрөгийн дараах алдааг залрууллаа. Үүнд:

- Сумын ОНСХ-ийн хөрөнгө оруулалтаар нийлүүлэгдсэн 9,579.0 мянган төгрөг тоног төхөөрөмж, 2,421.0 мянган төгрөгийн бараа материал, төсвийн хөрөнгөөр худалдаж авсан 2,587.2 мянган төгрөгийн принтер, гал тогооны цахилгаан хэрэгсэл, тооллогоор илэрсэн 365.5 мянган төгрөгийн бараа материалыг санхүүгийн үр дүнгийн тайланд тусгаагүй байна.
- Нийт 146.2 мянган төгрөг /Цалингийн 66.4 мянган төгрөг, НДШ-ийн илүү төлөлт 79.8 мянган төгрөг/ -ийн авлага, 1,550.9 мянган төгрөгийн бараа материалын өр төлбөрийг санхүүгийн тайланд тусгаагүй байна.
- Санхүүгийн үр дүнгийн тайланд 146.2 мянган төгрөгийн хоолны зардлыг цалингийн зардалд ангилал буруу бүртгэсэн байна.
- Биет бус хөрөнгөд 42.2 мянган төгрөгийн элэгдлийн зардал байгуулаагүй байна.

Аудитаар нийт **12,569.1** мянган төгрөгийн зөрчил илэрч 254.4 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 12,314.7 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага өгөв.

### **5.1 Төлбөрийн акт**

1. Тус цэцэрлэгийн жижүүрийн орон тоонд түр тушаалаар ажиллаж байгаа Х.Пунцагт 254.4 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон байна. Энэ нь Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтын 4.2-д “Энэ журмын 4.1-д заасан албан хаагч гэдэгт сургалтын байгууллагын төсвөөс цалинждаг орон тооны ажилтан хамаарна.” гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон үр дүнгийн урамшууллыг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох.

### **5.2 Албан шаардлага**

1. Төсвийг зохистой удирдаагүй, төлбөр тооцоог урьдчилан хянаагүйн улмаас 146.2 мянган төгрөгийн цалин, НДШ-ийн авлага, 1,550.9 мянган төгрөгийн түлш халаалтын өр төлбөр үүсгэсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх албан шаардлага хүргүүлэх.

2. Тайлант оны эцэст нөөцлөх шаардлагагүй 10,617.6 мянган төгрөгийн хүнсний материалыг худалдан авч нөөцөлсөн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6 дахь “нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах,

шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Хүнсний үлдэгдлийг 2024 оны хэрэглээнд суутган тооцох, их хэмжээгээр бараа материал нөөцлөхгүй байх албан шаардлага хүргүүлэх.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар үнэ төлбөргүй хүлээн авсан тоног төхөөрөмж, бараа материалыг орлогод бүртгээгүй.	1	12,000.0	1	12,000.0			1	12,000.0				
Төсвийн хөрөнгөөр худалдаж авсан тоног төхөөрөмжийг бараа материалын дансанд бүртгэсэн.	1	2,587.2			1	2,587.2	1	2,587.2				
Тооллогоор илэрсэн бараа материалыг орлогод бүртгээгүй.	1	365.5	1	365.5			1	365.5				
Санхүүгийн тайланд авлагыг тусгаагүй.	1	146.2	1	146.2			1	146.2				
Санхүүгийн тайланд өр төлбөрийг тусгаагүй.	1	1,550.9	1	1,550.9			1	1,550.9				
Цалингийн зардлыг илүү тайлагнасан.	1	146.2			1	146.2	1	146.2				
Элэгдэл байгуулаагүй.	1	42.2	1	42.2			1	42.2				
<b>Дүн</b>	<b>7</b>	<b>16,838.2</b>	<b>5</b>	<b>14,104.8</b>	<b>2</b>	<b>2,733.4</b>	<b>7</b>	<b>16,838.2</b>				

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Цалин илүү олгосон.	1	254.4	1	254.4								
Хүнсний материалын	1	10,617.6			1	10,617.6						

нөөц үүсгэсэн.										
Авлага үүсгэсэн.	1	146.2			1	146.2				
Өр төлбөр үүсгэсэн	1	1,550.9			1	1,550.9				
<b>Дүн</b>	<b>4</b>	<b>12,569.1</b>	<b>1</b>	<b>254.4</b>	<b>2</b>	<b>12,314.4</b>				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны 2 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн.	1	-					1	-
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>-</b>					<b>1</b>	<b>-</b>
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
<b>Дүн</b>	<b>-</b>	<b>-</b>					<b>-</b>	<b>-</b>
<b>Нийт дүн</b>	<b>1</b>	<b>-</b>					<b>1</b>	<b>-</b>